



141

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 83

Мандалговь

┌ Ундсэн хөрөнгө бүртгэх тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Сайнцагаан сумын төсвийн хөрөнгөөр худалдан авсан 15,000,000 /арван таван сая/ төгрөгийн “Приус-30” маркийн автомашиныг үндсэн хөрөнгөнд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга (Б.Оюунчимэг)-г дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 8 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын  
08-ний өдрийн 8.3 тогтоолын хавсралт

**Сайнцагаан сумын үндсэн хөрөнгөнд бүртгэх  
тээврийн хэрэгслийн мэдээлэл**

| Д/Д             | Тээврийн хэрэгслийн төрөл | Марк     | Улсын бүртгэлийн |        | Үйлдвэрлэсэн он | Ашиглалтад орсон огноо | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ                               | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэх өртөг                                |
|-----------------|---------------------------|----------|------------------|--------|-----------------|------------------------|-----------------|--------------------------------------------|-----------------------|--------------------------------------------|
|                 |                           |          | Сери             | дугаар |                 |                        |                 |                                            |                       |                                            |
| 1               | Суудлын                   | Приус-30 | ДУА              | 07-06  | 2010он          | 2020он                 | 100,000         | 15,000,000                                 | 0                     | 15,000,000                                 |
| <b>Нийт дүн</b> |                           |          |                  |        |                 |                        |                 |                                            |                       |                                            |
|                 |                           |          |                  |        |                 |                        |                 | <b>15,000,000 /арван таван сая/ төгрөг</b> |                       | <b>15,000,000 /арван таван сая/ төгрөг</b> |